

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 3 дугаар сар

1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр 16 ердийн даатгалын компани, 1 урт хугацааны даатгалын компани, 6 даатгалын зуучлагч үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр даатгалын байгууллагуудын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 3 дугаар сарын байдлаар харуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд :

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-I	2010-II	2010-III	Нийт
1	Даатгалын нийт хураамж	910 215,8	1 399 842,7	2 584 022,9	4 894 081,4
2	Олгосон нийт нөхөн төлбөр	404 565,6	345 313,2	899 945,5	1 649 824,4
3	Давхар даатгалд төлсөн хураамж	53 027,2	150 552,1	240 750,1	444 329,4
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	5 787,0	3 872,0	7 585,0	17 244,00
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	200 000 000,0	49 097 880,0	6 268 000,0	
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	37 513,7	37 145,0	227 184,0	

Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК нь “Багануур” ХК-ийн Хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгалын гэрээний нөхөн төлбөрт 227,2 сая төгрөг олгосон байна.

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа, сая төгрөгөөр



Даатгалын компаниудын 3 дугаар сард төвлөрүүлсэн даатгалын хураамжийн орлого 2 дугаар сарынхаас 1,6 дахин өссөн бол даатгалын нөхөн төлбөр 2,6 дахин өссөн байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд : /мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-I	2010-II	2010-III	Нийт
1	Даатгалын нийт хураамж	2 570,7	40 929,4	2 957,6	46 457,8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	410,0	1 935,9	765,0	3 110,9
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	-	27 440,0	27440,0
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	11 гэрээ	9 гэрээ	6 гэрээ	26 гэрээ
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	6 гэрээ	4 гэрээ	3 гэрээ	13 гэрээ
	-Байгууллагын хугацаат даатгалд	1 гэрээ /177 хүн/	5 гэрээ /686 хүн/	3 гэрээ /255 хүн/	9 гэрээ /1118 хүн/
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	4 гэрээ /12 хүн/	-	-	4 гэрээ /12 хүн/
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	10 000,0	20 000,0	15 000,0	
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	360,0	400,0	400,0	

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 3 дугаар сард хийгдсэн даатгалын гэрээнүүдээс “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээгээр 3 хүн, “Байгууллагын хугацаат амьдралын даатгал”-ын 3 гэрээгээр 255 хүнийг даатгалд хамруулж 2,9 сая төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. 2010 оны 1 дүгээр улиралд нийт 46,4 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлснээс 88,1 хувь буюу 40,9 сая төгрөгийн хураамжийн орлогыг 2 дугаар сард төвлөрүүлсэн байна.

Гэнэтийн осол, эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр 1,1 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд : /мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-III
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	15 865,7
2	Даатгалын зуучлагчийн орлого	7 435,1
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	29,00
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	2 954 787,5

Даатгалын зуучлагч компаниудаас “Аме” ХХК нь 2010 оны 3 дугаар сарын мэдээг өгөөгүй тул 5 даатгалын зуучлагч компанийн хувьд сарын мэдээг гаргалаа.

2010 оны 3 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 2,9 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 29 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучилж 7,4 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна. Даатгалын зуучлагчийн орлогын 33,9 хувийг “Ачит ундарга” ХХК, 30,8 хувийг “Эм Жи Ай Би” ХХК, 25,2 хувийг “Лояалти солюшн” ХХК, 10,1 хувийг “Асимон брокерс” ХХК бүрдүүлж байгаа бол “Скай эрдэнэ” ХХК нь даатгалын зуучлалын орлого олоогүй байна.